



ТӨВ АЙМГИЙН ТЭЭВЭР АВТО ЗАМЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 70272582

И-мэйл

Аудитын менежер

Т.Майцэцэг

Утас: 70273465

И-мэйл

Аудитор

О.Сосор

Утас: 70273204

И-мэйл

• Танилцуулга	1-7
• Санхүүгийн дотоод хяналт	7
• Гол шийдлүүд	8
• Залруулаагүй алдаа	8
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	8
• Аудитын санал дүгнэлт	8

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

Төв аймгийн Тээвэр авто замын газрын 2013 оны Санхүүгийн тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид аймгийн Тээвэр авто замын газрын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Тээвэр авто замын газрын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Тээвэр авто замын газрын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

- Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. Тээвэр авто замын газрын урсгал санхүүжилт 2013 онд 168690.4 мянган төгрөгөөр батлагдсан байна. 2013 онд улсын төсвөөс 166335.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн хөгжлийн сангаас 5000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 27951.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 32882.8 мянган төгрөг харилцах дансаар орсон байна .

- Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг шалгаж үзэхэд барилга байгууламжийн дансанд өндөр довын цагдаагийн пост 531590.2 мянган төгрөгийн бүртгэлтэй байгаа нь зах зээлийн үнээс хэд дахин өндөр үнэтэй, жилд 66448.7 мянган төгрөгийн элэгдэл бодогдож байгаа зөрчил илэрсэн.

- МТОЙль ХХК-д 12490.9 мянган төгрөг шилжүүлж, няравын тайлангаар 11972.1 мянган төгрөгийн шатахууныг орлого авч 518.8 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй зөрчил илэрсэнд акт бичигдсэн.

- Тус байгууллага нь дотоод хяналт шалгалт хийх комиссыг 2012.11.06 ны

өдрийн 44 тоот тушаалаар 4 хүний бүрэлдхүүнтэй, комиссын даргаар АТХУБайцаагч Н.Аасүрэнг томилсон байна. Дотоод хяналтын комисс нь 2013 онд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан боловч дотоод хяналт шалгалтыг хийгээгүй байсан.

ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа .

-Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү

Нийт зөрчил нь материаллагын урьдчилан тогтоосон түвшингээс бага байгаа тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргахаар Ерөнхий аудиторт санал оруулсан байгаа.

Аймгийн Ерөнхий Аудитор 2014 оны 2-р сарын 18-ны өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч Д.Солонго олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.02.19

Танилцуулга

1. Бид аймгийн Тээвэр авто замын газрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба аймгийн Тээвэр авто замын газрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд аймгийн Тээвэр авто замын газрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь аймгийн Тээвэр авто замын газрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Аймгийн Тээвэр авто замын газрын даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.
4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Тээвэр авто замын газрын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1. Орлого, санхүүжилтийн талаар

Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна. Тээвэр авто замын газрын урсгал санхүүжилт 2013 онд 168690.4 мянган төгрөгөөр батлагдсан байна. 2013 онд улсын төсвөөс 166335.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн хөгжлийн сангаас 5000.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 27951.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 32882.8 мянган төгрөг харилцах дансаар орсон байна. Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан.

2. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн 2013 оны эхний үлдэгдэл 7506058.9 мянган төгрөг, тайлант онд үндсэн хөрөнгө нь 995868 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас хасагдсан хөрөнгө байхгүй, оны эцэст 7516017.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үндсэн хөрөнгийн орлогын тайлан хийгээгүй байсан. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг программаас хэвлэн гаргаж нягтлан бодогч, няравууд гарын үсэг зурсан байсан. Төсвийн хөрөнгөөр 9958.8 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдан авч данс бүртгэлд тусгасан байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг ТАЗГазрын даргын 2013.12.02 ны өдрийн А/32 тоот тушаалаар 4 хүний бүрэлдхүүнтэй тооллогын комиссын комиссыг томилсон. Тооллогын комиссууд тооллогыг чанар муутай хийсэн байна. Тооллогын комиссууд тооллогыг хийж илтгэх хуудсанд үндсэн хөрөнгийг нийт байгуулсан элэгдэл хассан дүнгээр бичсэн байсан. Үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлийг шалгаж үзэхэд барилга байгууламжийн дансанд өндөр довын цагдаагийн пост 531590.2 мянган төгрөгийн бүртгэлтэй байгаа нь зах зээлийн үнээс хэд дахин өндөр үнэтэй байгаа зөрчил илэрсэн.

2012 оны санхүүгийн тайлангийн аудитаар хөрөнгийн тооллогыг “ТБОНӨ тухай хууль”-ийн 70 дугаар зүйлд заасан хугацаанд, чанартай явуулж, тооллогын үр дүнг байгууллагын төсвийн менежерт танилцуулж байх гэсэн зөвлөмж өгөгдсөн байхад хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон.

3. Бараа материал

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна. Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага, өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 3190.4 мянган төгрөг, орлого 21680.0 мянган төгрөг, зарлага 18171.3 мянган төгрөг гарч, оны эцэст 6699.0 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарж албажсан байна. Автомашинд сэлбэг худалдаж авахдаа техникийн комиссын акт үлдэхгүйгээр авч зарлагдаж байна. .

4. Цалингийн талаар

Тээвэр авто замын газрын даргын 2013.01.28 ны өдрийн 02 тоот тушаалаар цалинг шинчлэн тогтоосон байна. Цалингийн санг 127426.3 мянган төгрөгөөр батлагдсан. Тайлант онд 80740.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Сумдын тээвэр зохицуулагч нарын цалинг орлогын 40 хувиар 2013.01 сараас 07-р сарыг дуустал бодож олгож, 2013.07.01 нээс эхлэн тогтмол цалин бодож олгосон байна. Ажиллагсдад байгууллагын дотоод журамд заасны дагуу хоолны мөнгийг өдрийн 1500 төгрөгөөр бодож олгосон байна.

Ажиллагсдад ур чадварын нэмэгдэл олгохдоо 1995 оны 96-р тогтоолоор Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам –ын 3-т ур чадварын нэмэгдлийн доод хэмжээ нь тухайн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 10 хувь байна гэж заасан байдаг. Гэтэл ур чадварын нэмэгдлийг няравт 5 хувиар бодож олгож дээрхи тогтоолыг зөрчсөн байна. Ур чадварын нэмэгдлийг үйлчилгээний ажиллагсдын ажлыг дүгнэхгүйгээр тогтмол олгож байна.

5. Бараа үйлчилгээний зардал

ТАЗГ нь өөрийн байргүй тул АЗЗА ХК байранд байрлаж түрээсийн төлбөрт сард 224.2 мянган төгрөг төлж байна. Шатахууны зарцуулалтын байдлыг шалгаж үзэхэд МТОЙль ХХК-иас шатахууныг зээлээр авч дараа нь мөнгийг төлдөг байна. Материалын тайланг шалгахад авсан шатахуунд орлогын падаан бичүүлж авдаггүй авсан шатахууны хэмжээгээр нярав орлогын тайлан гаргадаг зөрчил илэрсэн.

2013.12.23 нд 700.0 мянгантөгрөг шилжүүлж ,2014.01.03 нд шатахуун толаныг авч орлогод авсан байгаа нь бүртгэлийг цаг хугацаанд нь хөтлөхгүй байна.Тээврийн орлогоос 22051.4 мянган төгрөгийг тээвэр зохицуулагч нарын цалин, шатахуун ,замын тэмдэг,нормчлолын үнэнд зарцуулсан байна.Төрийн санд 2013.12.02 нд нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт гаргаж орлогоос шатахуунд 3400.0 мянган төгрөгийг, ном хэвлэл авахад 300.0 мянган төгрөгийг,10670.0 мянган төгрөгийг эд хогшил авахад зарцуулсан байна. Дээрхи зардлуудын гүйцэтгэлийг үр дүнгийн тайланд бодит байдлаар тайлагнасан байсан.

6.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна. Харилцахаас кассад 857.0 мянган төгрөг авч зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276-р тушаалаар батлагдсан “төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам,,-ыг баримтлан ажилласан байна.Харилцах данснаас тээврийн орлого 23323.7 мянган төгрөгийг Зам тээврийн яаманд төвлөрүүлсэн.Шуудан үйлчилгээний газарт шуудан хүргэлтийн нөхөн олговорт 5000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 65881.8 мянган төгрөгийг Сангийн яаманд төвлөрүүлж Төсвийн тухай хуулийн 45.2-т “төсвийн захирагчийн зарцуулаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд шилжүүлнэ,, гэсэн заалтыг мөрдөж ажилласан байна. Харилцах данснуудын үлдэгдлийг төрийн сангаар баталгаажуулсан. Нэмэлт санхүүжилтын дансны үлдэгдэл 1458.9 мянган төгрөгийн үлдэгдэл нь төрийн сангийн үлдэгдэлтэй тохирч байна.Төрийн сангаар гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн сангийн тэмдэг дарж баталгаажсан байна.

7.Авлага ,өглөгийн талаар

- Цахилгааны үнэнд 184.4 мянган төгрөг ХҮТ-өөс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн байна.
- НДХэлтэстэй тооцоо нийлсэн актаар НДШ –ийн өр ,авлагагүй гарсан байна.
- МТОЙль ХХК-д 12490.9 мянган төгрөг шилжүүлж, няравын тайлангаар 11972.1 мянган төгрөгийн шатахууныг орлого авч 518.8 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй зөрчил илэрсэнд акт бичигдсэн.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн. Харилцагч байгууллагуудаас Магнай трейд, Авто тээврийн үндсэний төв, Холбооны газар, АЗЗА ТӨХК, Шуудан үйлчилгээний газар,Эрчим хүчний газартай тооцоо нийлж актыг үйлдэж тооцооны баримтын жагсаалт үйлдсэн байна.

8. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Төрийн хяналт шалгалтын тухай хууль”-ийн 6.4-д заасныг үндэслэн “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батласан журмын дагуу байгууллага бүр үйл ажиллагааны онцлогт тохирсон дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтанг томилон ажиллуулах ёстой. Тус байгууллага нь дотоод хяналт шалгалт хийх комиссыг 2012.11.06 ны өдрийн 44 тоот тушаалаар 4 хүний бүрэлдхүүнтэй, комиссын даргаар АТХУБайцаагч Н.Аасүрэнг томилсон байна. Дотоод хяналтын комисс нь 2013 онд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулсан боловч дотоод хяналт шалгалтыг хийгээгүй байна.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5.Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6.Эдгээр асуудлуудыг ААГ болон аймгийн Тээвэр авто замын газрын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7.Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилт

- Хөрөнгийн тооллогыг “ТБОНӨ тухай хууль”-ийн 70 дугаар зүйлд заасан хугацаанд, чанартай явуулж, тооллогын үр дүнг байгууллагын төсвийн менежерт танилцуулж байх.
- Няравын программыг үйл ажиллагаандаа ашиглах.
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед эд хөрөнгийн тооллогыг заавал хийж ажил хүлээлцсэн акт үйлдүүлэх.
- Зардлуудын бүлгээс бүлэгт шилжүүлэхдээ Сангийн сайдын 2010 оны 48 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-ын 5.4, 5.5-д заасныг баримтлах, мөн тушаалаар

батлагдсан “Зардлын зүйл тус бүрээр хяналт тогтоох зардлын зүйл”-д бусад зардлаас болон энэ зардлын зүйлүүдээс бусад зардалд шилжүүлэн зарцуулахгүй, журмыг хэрэгжүүлж ажиллах.

- Үнэт цаасны тооцоог хагас, бүтэн жилээр ТХОХЗАлбатай хийж үлдэгдлийг баталгаажуулж байх гэсэн зөвлөмжүүд өгөгдсөн.

2012 оны санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг Аудитын газарт гаргаж ирүүлээгүй байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд **зөрчилгүй** санал дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.02.19